



УЛСЫН ФИЛАРМОНИЙ ДАРГА
Ч.ДАВААСҮРЭН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.09.20 № 3/261
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Улсын филармоний удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын филармоний 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

УХА0122
\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0220\AC12\Doc

09.09.2017



УЛСЫН ФИЛАРМОНИЙ ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитынтайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

**САГ-ын дарга, тэргүүлэх
аудитор: С.Энхзаяа**

Утас: 261663

Цахим

хаяг: enkhzayas@audit.gov.mn

Хавсралт 1: Агуулга /ТАБ-СТА-С-2/

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ/ТАБ-СТА-С-1/

Хавсралт 3: Менежментийн захидал /ТАБ-СТА-С-3/

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн
тайлан

Аудитын менежер: Н.Золзаяа

Утас: 260512

Дундманхайдай аудит ХХК

аудитор: Ж.Бямбажав

Д.Төмөрбаатар

Утас: 325262

Цахим хаяг: www.dumaudit.mn

2016 он 02 сарын 04 өдөр

ТАБ-ын

хаяг:

Үндэсний аудитын

газар

Байршил: Чингэлтэй дүүрэг

Цахим хуудас: www.audit.mn

1. Оршил
2. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
3. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
4. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа
5. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Оршил

Үндэсний аудитын газрын захиалгаар “Дундманхайдай аудит” ХХК нь Улсын филарманий 2016 оны санхүүгийн тайланд аудит хийж тайлангийн дүгнэлтийг Улсын филарманий удирдлага болон Үндэсний аудитын газарт танилцуулж байна.

Менежментийн захидалд санхүүгийн дотоод хяналтын журмыг сайжруулах талаархи бидний зөвлөмжүүдэд Улсын филарманий удирдлага, санхүүгийн ажилтнуудын саналыг солилцон тусгасан болно.

2. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалт, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсэг, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2013 оны 158 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх журам”-ын 2.7-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын филарманий төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2017/316/СТА-ТШЗ / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Улсын филарманий төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Улсын филарманий төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцыг 2016 оны 10 дүгээр сарын 05-ноос 2016 оны 11 дугаар сарын 01-ны

БНМАУ-ын Соёлын Яамны 1957 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 118 тоот тушаалаар Монголын Радио Хорооны дэргэд Симфони найрал хөгжим байгуулагдсанаар Улсын филармонийн үндсэн суурь тавигдаж, улмаар БНМАУ-ын Сайд нарийн зөвлөлийн 1972 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 283 тоот тогтоолоор Мэдээлэл, радио телевизийн улсын хорооны “Баян Монгол” джаз найрал хөгжим, Улсын Ардын Дуу Бүжгийн Чуулга, “Соёл-Эрдэнэ” дуу хөгжмийн хамтлагийг нэгтгэн Ардын жүжигчин, Төрийн шагналт Ц.Намсрайжавын санаачлагаар Улсын Филармонийг байгуулсан юм.

Симфони найрал хөгжмийг үндэслэн байгуулагч Ардын жүжигчин, Төрийн шагналт хөгжмийн зохиолч Ц.Насрайжав нь 30 гаруй жил тус байгууллагын дарга, уран сайхны удирдагч, ерөнхий удирдаачаар ажиллаж, ард түмэнд сонгодог урлаг сурталчлах Монголын болон гадаадын орнуудын хөгжмийн зохиолчдын уран бүтээлүүдийг туурвин бүтээх үйлсэд ихээхэн хувь нэмэр оруулсныг Төр засгаас өндрөөр үнэлж Нийслэлийн засаг даргын 1992 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/28 тоот захирамжаар Улсын Филармонийг Монгол улсын Ардын жүжигчин, Төрийн шагналт хөгжмийн зохиолч, удирдаач, Улсын Филармоний симфони найрал хөгжмийг үндэслэн байгуулагч агсан Ц.Намсрайжавын нэрэмжит болгосон юм.

Улсын Филармони одоогоор Симфони найрал хөгжим, “Баян Монгол” джаз найрал хөгжим, “Морин Хуурын” чуулга зэрэг хамтлагууд ажиллаж байна.

Нийгэмд үзүүлж байгаа үйлчилгээ:

- Ардын хөгжмийн уран бүтээлүүд
- Дэлхийн сонгодог хөгжийн уран бүтээлүүд
- Монголын сонгодог уран бүтээлүүд
- Орчин үеийн жааз хөгжийн уран бүтээлүүд
- Дэлхийн болон олон улсын жааз хөгжмийн уран бүтээлүүд
- Хүүхэд, залуучуудад зориулсан орчин үеийн бүх төрлийн уран бүтээлүүд
- Уртын болон, ардын богино дуу, зохиолын болон эстрадын дууны уран бүтээлүүд
- Хүүхэд, залуучуудад зориулсан лекц,концерт /Тайлбартай/
- Бүх нийтийн хөгжмийн боловсролд зориулсан лекц концерт /Тайлбартай/
- Уран бүтээлчдийн тайлан тоглолтууд
- Гадаадын хамтлаг, дуучид,хөгжимчид, удирдаачидын тоглолт, хамтарсан тоглолт
- Соёлын солилцооны хөтөлбөрийн хүрээнд гадаад орнуудад тоглолт зохион байгуулах
- Баяр наадам, төрийн хүндэтгэл, ойн арга хэмжээнүүдэд оролцох

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “байгууллагын дарга төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Улсын филармоний дарга Ч.Даваасүрэн нь төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Улсын филармоний 2016 оны төсвийг

БСШУССайдын багцаас санхүүжүүлж төлбөр тооцоог тус яамны төрийн сангийн нэгжээс хэрэгжүүлж байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

5. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Улсын филармоний төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 21-г гүйцэтгэв.

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Улсын филармони нь санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Нью-Баланс аудитын компаниар хийлгэж байгууллагын даргаар батлуулан 2015 оны 06 дүгээр сарын 10-нээс эхлэн мөрдөн ажиллаж байна. Санхүүгийн тооцоолох ХХК-ний "Acoulous 3.0" програмыг хэрэглэж байна.

Уг програм нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандарт болон Монгол улсын НББ-ийн стандартад нийцсэн.

Тус хувилбар нь төсөвт байгууллагын нягтлан бодогчид өдөр тутмын үйл ажиллагааны анхан шатны мэдээллийг бүртгэх, санхүүгийн мэдээ, тайлан гаргахад зориулагдсан байна.

Улсын филармоний санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Улсын филармоний санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Улсын филарманий дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтаар гүйцэтгэж буй ажлын биелэлт, дүгнэлт хийх ажиллагаа дундач түвшинд байна.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу БСШУСЯамны төрийн сангийн нэгжээр харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Улсын филарманий төсвийн захирагч нь 2016 оны жилийн эцсийн дүнгээр төсвөөс урсгал зардалд 1,466,843,1 мянган төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний орлогоор 90,047,6 мянган төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгал зардалд 1,552,343,1 мянган төгрөг батлагдсанаас 1,551,682,8 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 600,0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар улсын болон салбарын хэмжээний арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласны гүйцэтгэлийн 22,500,0 мянган төгрөгийг дээд шатны төсвөөс санхүүжүүлсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахь ажилуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

1. Шилэн дансны нэгдсэн мэдээллийн санд батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, 5 сая төгрөгөөс дээшхи гүйлгээг сар бүр оруулан ажилласан бөгөөд харин тайлбарыг хангалттай түвшинд мэдээлээгүй байна.
2. Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт хийгдээгүй тул энэ төрлийн мэдээллийг тусгаагүй байна.
3. Бусад мэдээллийн хэсэгт байгууллагын орон тоонд гарсан өөрчлөлтийг сар бүр мэдээлэн ажилсан байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 21 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 21 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Байгууллагын батлагдсан орон тоо, цалингийн сан түүний гүйцэтгэл, байгууллага хүмүүстэй хийх төлбөр тооцоо, харилцах болон бэлэн мөнгөний дансны гүйлгээ, хөрөнгө материалын бүртгэл тооллого, тооцоо бодолт, анхан болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт зэргийг холбогдох хууль тогтоомжийн заалтуудтай тулган шалгахад дараах эрсдлүүд илэрсэн болно.

1. БСШУСайдын 2011 оны 294 дугаар тушаалаар тогтоосон орон тооны хязгаарыг хэтрүүлэн жилийн дунджаар сард 12 хүнийг илүү ажиллуулж цалингийн зардлыг 74,389,6 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 8,182,8 мянган төгрөгөөр тус тус илүү зарцуулсан
2. Хөрөнгө, материалыг данс бүртгэлд тусгах ажлын хүрээнд биет хөрөнгөөр бүртгэх 2,412,4 мянган төгрөгийн хөрөнгийг материалыг дансанд бүртгэж тайланд тусгасан
3. Байгууллага хооронд үүссэн үндсэн үйл ажиллагааны орлогын 3000,0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн
4. Шилэн дансны мэдээллийн санд төсвийн гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл тайлбарыг бүрэн оруулж тайлагнах асуудал шаардлагын хэмжээнд хүрээгүй зэрэг болно. Эдгээр асуудлуудыг тайлангийн аудитаар илэрсэн зөрчилүүд түүнийг шийдвэрлэсэн байдал хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Улсын филармоний төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо, төлбөр хураамж, зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 90хувь, мөнгөн хөрөнгийн 80 хувь, нийт зардлын 70 хувь, нийт хөрөнгийн 40 хувийг тус тус эзэлж байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад байгууллагад илэрсэн зарим зөрчлийг шууд захирагчын анхааралд хандуулж байна. Эдгээр зөрчлийг захирал, нягтлан бодогч нартай зөвшилцөн санал солилцсон болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. БСШУСайдын 2011 оны 294 дугаар тушаалаар батлагдсан орон тооны дээд хязгаарыг 159 орон тоогоор тогтоосон боловч оны дундаж гүйцэтгэлээр 171 хүн ажиллуулж орон тоог 12 хүнээр дундажаар тооцсоноор цалингийн санг 74389,6 мянган төгрөгөөр ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 8182,8 мянган төгрөгөөр илүү

зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтын батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, цалингийн санг тогтоох гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид дээрхи алдааг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгсөн болно.

2. 2015 онд үүссэн МУБИСургуулиас авах 3000,0 мянган төгрөгийн ажил үйлчилгээний орлогын авлагыг барагдуулалгүйгээр хоёр жил болсон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өгсөн зөвлөмжийн хүрээнд авлагын 3000,0 мянган төгрөгийг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан барагдуулах арга хэмжээ авах.

3. 2412,4 мянган төгрөгийн үнэ бүхий өнгөт телевизорыг хангамжийн материалын дансанд бүртгэж биет хөрөнгөөр бүртгээгүй нь Сангийн сайдын 2006 он 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.46, 4.47, 4.48-д нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өгсөн зөвлөмжийн хүрээнд 2412410 төгрөгийн телевизорыг хангамжийн материалын данснаас биет хөрөнгийн дансанд бүртгэж тайлан тэнцэлд тусгах

Эдгээр зөрчил нь дараах хуулийн холбогдох заалтууд болон санхүүгийн тайлангийн толилуулгын батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”
- Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төсөвлөж зарцуулах”
- Иж бүрэн байх: “бүртгэгдээгүй хөрөнгө, өр төлбөр, ажил гүйлгээ, үйл явдал буюу дэлгэж харуулаагүй зүйл үгүй байх”.
- Тохиолдсон байх: “байгууллагад хамаатай ажил гүйлгээ, үйл явдал тухайн хугацаанд тохиолдсон байх”.
- Үнэн зөв байдал: “ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журамд нийцэж байх”

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад материаллаг бус 87984,8 мянган төгрөгийн зөрчлийг залруулах боломжгүй байсан бөгөөд цаашид дээрхи зөрчлийг давтан гаргуулахгүй байх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж өгч ажиллаа.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад чухал асуудал үгүй байна. Оны дундуур болон эцсээр нягтлан бодогч өөрчлөгдсөнөөс шалтгаалан тайланг хугацаанд нь өгсөн боловч санхүүгийн тайлан мэдээнүүдтэй холбоотой тодруулах зүйл олон гарсан болно.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Улсын филармоний 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Улсын филармоний төсвийн 2016 оны жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 87,984,8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 87,984,8 мянган төгрөгийн материаллаг бус алдаа зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа. Төсөвт байгууллагын хувьд нийт зардлаар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзэн нийт зардлын 1 хувиар буюу 15,523,4 мянган төгрөгөөр тогтоон илэрсэн зөрчил нь материаллаг байдлын түвшинд байгаа тул **зөрчилгүй** санал дүгнэлт өгөх санал оруулж байна.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2015 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Дунд манхайдай Аудит” ХХК 7 зөвлөмж өгснийг хэрэгжүүлсэн байна. Зөвлөмж биелэгдсэн байна

17. Зөвлөмж

Зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

18. Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын филармоний төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

САГ-ЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.Энхзаяа

АУДИТЫН МЕНЕЖЕР

Н.Золзаяа

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Д.Төмөрбаатар



Улсын филармоний 2016 оны санхүүгийн тайлан

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Орон тоо, цалингийн сангийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

Авлагын талаар

Асуудал 3

Бараа материалын талаар

2010оны 3 дугаар сарын01

Менежментийн захидал

“ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ”ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Улсын филармоний удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Улсын филармоний удирдлага, санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1

Орон тоо цалингийн сангийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

БСШУСайдын 2011 оны 294 дугаар тушаалаар батлагдсан орон тооны дээд хязгаарыг 159 орон тоогоор тогтоосон боловч оны дундаж гүйцэтгэлээр 171 хүн ажиллуулж орон тоог 12 хүнээр, дундажаар тооцсоноор цалингийн санг 74389,6 мянган төгрөгөөр ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 8182,8 мянган төгрөгөөр тус тус илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалтын “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, цалингийн санг тогтоох” гэсэн заалтыг зөрчиж байна

Эрсдэлүүд

Байгууллагын ажиллагсадын ажлын байрны хэрэгцээ шаардлага оновчгүй төлөвлөгдөх, ажилтны ажлын ачаалал харилцан адилгүй байх, үйл ажилгааны үр дүнг тооцоход хүндрэл үүсэх

Төсөв зориулалт бусаар зарцуулагдах, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн үр дүн буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй.

ҮАГ-ын зөвлөмж

Салбарын сайдын тогтоосон орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах, ажлын онцлог шаардлагатай гэж үзвэл БСШУСЯаманд хүсэлт тавьж асуудлыг шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмж өгсөн.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийг хүлээн авч холбогдох арга хэмжээг зохион байгуулан хариуг танилцуулна.

Асуудал 2

Тэргүүлэх ач холбогдол №2

Авлагын талаар

ҮАГ-ын ажиглалт

2015 онд үүссэн МУБИСургуулиас авах 3000,0 мянган төгрөгийн ажил үйлчилгээний орлогын авлагыг барагдуулалгүйгээр хоёр жил болсон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан “ Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Өгсөн зөвлөмжийн хүрээнд авлагын 3000,0 мянган төгрөгийг 2017 оны 1 дүгээр улиралд багтаан барагдуулах арга хэмжээ авах.

Эрсдэлүүд

Төсвийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.4.1-д “ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах.” гэсэн заалт зөрчигдөх эрсдэлтэй

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу хүлээн зөвшөөрч, холбогдох арга хэмжээ авч шийдвэрлэнэ

Бараа, материалын талаар

ҮАГ-ын ажиглалт

2412,4 мянган төгрөгийн үнэ бүхий өнгөт телевизорыг хангамжийн материалын дансанд бүртгэж биет хөрөнгөөр бүртгээгүй нь Сангийн сайдын 2006 он 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.46, 4.47, 4.48-д нийцээгүй байна.

Эрсдэлүүд

Хөрөнгийн өртөг буруу тайлагнах, ашиглах хугацааны элэгдэлээс хамааран хөрөнгийн ашиглалт зарцуулалтанд сөрөгөөр нөлөөлж элэгдэл тооцох хууль эрх зүйн акт зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Өгсөн зөвлөмжийн хүрээнд 2412,4 мянган төгрөгийн телевизорыг хангамжийн материалын данснаас биет хөрөнгийн дансанд бүртгэж тайлан тэнцэлд тусгах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч, хариу мэдэгдэнэ

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Улсын филармоний удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын филармоний 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР С.ЭНХЗАЯА

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАГНАЛЫН
ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС**

Аудитын нэр: Улсын филармоний төсвийн 2016 оны санхүүгийн тайлан

Аудитын код: САГ-2017/316/СТА-ТШЗ /

Аудитын багийн нэр: “Дундманхайдай аудит” ХХК- I баг

Тайлант жил : 2016 он

№	Аудитыг тайлагнах шатанд бүрдүүлэх баримтын нэр	Хяналт хийсэн огноо		Тайлбар
		Анхан шатны хяналт	Хоёр дахь шатны хяналт	
1	Аудитын тайлан			
2	Газрын даргаар гарын үсэг зуруулахаар бэлтгэсэн Аудитын гэрчилгээ			
3	Менежментийн захидал			
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан			
5	Санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай байгууллагын албан бичиг болон санхүүгийн тайлан			
6	Акт, албан шаардлагын төсөл			Байхгүй
7	Хянан удирдах ажилтнуудын үүргийн хэрэгжилт			Байхгүй

Бэлтгэсэн: “Дунд манхайдай аудит”ХХК, аудитор

Ж.Бямбажав
Д.Төмөрбаатар

Анхан шатны хяналт хийсэн:

Аудитын менежер

Н.Золзаяа

Хоёрдах шатны хяналт хийсэн:

САГ-ын дарга, тэргүүлэх аудитор

С.Энхзаяа

УЛСЫН ФИЛАРМОНИ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

1.31

/

№	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	00.00	00.00
2	Төсвийн байгууллагын харилцах	00.00	00.00
3	АВЛАГА	4,657,332.50	3,000,000.00
4	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,000,000.00	3,000,000.00
5	Бусад авлага	1,657,332.50	00.00
6	БАРАА МАТЕРИАЛ	45,859,128.78	52,951,893.00
7	Түүхий эд материал	14,562,100.00	17,703,325.00
8	Бэлэн бүтээгдэхүүн	00.00	500,000.00
9	Бусад Хангамжийн материал	30,529,549.78	34,748,568.00
10	Тасалбар урилга	767,479.00	00.00
11	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	50,516,461.28	55,951,893.00
12	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	589,669,610.57	383,389,150.61
13	Биет хөрөнгө	586,435,360.57	381,027,400.57
14	Авто тээврийн хэрэгсэл	81,800,000.00	81,800,000.00
15	Хуримтлагдсан элэгдэл	-44,914,666.56	-55,047,999.84
16	Машин, тоног төхөөрөмж	823,043,016.67	823,043,016.67
17	Хуримтлагдсан элэгдэл	-347,264,987.85	-516,119,554.93
18	Тавилга, аж ахуйн эд хогшил	81,030,800.16	81,030,800.16
19	Хуримтлагдсан элэгдэл	-40,062,206.77	-48,198,861.49
20	Бусад үндсэн хөрөнгө	49,832,435.72	49,832,435.72
21	Хуримтлагдсан элэгдэл	-17,029,030.80	-35,312,435.72
22	Биет бус хөрөнгө	3,234,250.00	2,361,750.04
23	Програм хангамж	3,490,000.00	3,490,000.00
24	Хасагдуулга	-255,750.00	-1,128,249.96
25	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	589,669,610.57	383,389,150.61
26	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	640,186,071.85	439,341,043.61
27	Богино хугацаат өр төлбөр	1,657,337.50	01.00
28	Өглөг	1,657,337.50	01.00
29	ХАОАТ өглөг	1,657,337.50	01.00
30	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,657,337.50	01.00
31	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,657,337.50	01.00
32	Засгийн газрын оруулсан капитал	390,738,376.57	390,738,376.57
33	Өмнөх үеийн үр дүн	162,967,801.97	162,967,801.97
34	Тайлант үеийн үр дүн	00.00	-199,187,691.74
35	Дахин үнэлгээний зөрүү	84,822,555.81	84,822,555.81
36	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	638,528,734.35	439,341,042.61
37	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	640,186,071.85	439,341,043.61

Бэлтгэсэн: Аудитор

Д.Төмөрбаатар

УЛСЫН ФИЛАРМОНИ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

.31

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	00.00
2	Улсын төсвөөс	1,598,124,403.79	1,489,343,100.00
3	Урсгал	1,455,652,900.00	1,466,843,100.00
4	Хөрөнгийн	1,449,000.00	00.00
5	Нэмэлт санхүүжилтийн орлого	141,022,503.79	22,500,000.00
6	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	79,520,000.00	22,500,000.00
7	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүр	58,080,000.00	00.00
8	Төсвийн урамшуулал	3,422,503.79	00.00
9	Бараа, үйлчилгээний орлого	92,427,303.00	90,047,676.09
10	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	92,427,303.00	90,047,676.09
11	Үндсэн үйл ажиллагааны орлого	91,018,958.00	90,047,676.09
12	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,408,345.00	00.00
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,690,551,706.79	1,579,390,776.09
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,857,843,444.89	1,759,051,367.83
15	АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	1,398,956,583.90	1,398,303,786.64
16	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,260,918,261.00	1,260,213,011.00
17	Цалин	1,260,918,261.00	1,260,213,011.00
18	Нийгмийн хамгааллын шимтгэл	138,038,322.90	138,090,775.64
19	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	114,067,153.90	113,304,379.29
20	Тэтгэврийн даатгалын шимтгэл	88,957,236.90	88,319,483.09
21	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	10,150,126.00	9,993,656.30
22	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,631,978.00	12,592,106.60
23	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,327,813.00	2,399,133.30
24	Эрүүл мэндийн даатгалын хураамж	23,971,169.00	24,786,396.35
25	Тогтмол зардал	48,950,000.00	41,677,200.00
26	Байрны түрээс	48,950,000.00	41,677,200.00
27	Хангамж, бараа материалын зардал	3,154,290.06	2,975,900.00
28	Бичиг хэргийн материал	842,100.00	655,700.00
29	Тээвэр, шатахууны зардал	1,190,400.00	1,072,700.00
30	Шуудан холбоо интернетийн төлбөр	742,100.00	1,100,800.00
31	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	379,690.06	146,700.00
32	Нормативт зардал	822,890.00	1,570,000.00
33	Нормын хувцас, зөөлөн эдлэл	822,890.00	1,570,000.00
34	Томилолт, зочны зардал	590,300.00	224,700.00
35	Дотоод томилолтын зардал	590,300.00	224,700.00
36	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	169,728,093.02	102,811,435.78
37	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	168,521,593.02	100,815,735.78
38	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	673,800.00	1,000,000.00
39	Даатгалын үйлчилгээний төлбөр	274,000.00	274,000.00
40	Тээврийн хэрэгслийн татвар	225,700.00	225,400.00

41	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00
42	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	00.00	463,300.00
43	Бараа үйлчилгээний бусад зардал	235,641,287.91	211,488,345.41
44	Татан төвлөрүүлэх	1,953,324.10	5,207,885.45
45	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	233,687,963.81	206,280,459.96
46	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,445,713.79	19,527,100.00
47	Бусад урсгал шилжүүлэг	39,445,713.79	19,527,100.00
48	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэм	34,753,710.00	19,527,100.00
49	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	4,692,003.79	00.00
50	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,897,289,158.68	1,778,578,467.83
51	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	-206,737,451.89	-199,187,691.74
52	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	00.00	00.00
53	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	00.00	00.00
54	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-206,737,451.89	-199,187,691.74

Бэлтгэсэн: Аудитор

Д.Төмөрбаатар

УЛСЫН ФИЛАРМОНИ

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

᠑᠖.12.31

/т

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Тусламж, санхүүжилтын орлого	1,596,675,403.79	1,500,635,121.00
2	Улсын төсвөөс	1,455,652,900.00	1,466,843,100.00
3	Урсгал	1,455,652,900.00	1,466,843,100.00
4	Нийгмийн даатгалын сангаас		11,292,021.00
5	Нэмэлт санхүүжилтийн орлого	141,022,503.79	22,500,000.00
6	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдса	79,520,000.00	22,500,000.00
7	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны х	58,080,000.00	00.00
8	Төсвийн урамшуулал	3,422,503.79	00.00
9	Бараа, үйлчилгээний орлого	88,018,958.00	100,401,968.59
10	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	88,018,958.00	100,401,968.59
11	Үндсэн үйл ажиллагааны орлого	86,652,657.00	90,047,676.09
12	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,366,301.00	00.00
	Туслах үйл ажилгааны орлого	00.00	10,354,292.50
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,684,694,361.79	1,601,037,089.59
14	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,645,248,648.00	1,581,509,989.59
15	Ажиллагчидтай холбогдсон зардал	1,397,215,926.90	1,409,595,811.64
16	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,258,814,322.00	1,271,505,036.00
17	Цалин	1,189,518,722.00	1,177,132,536.00
18	Унаа хоолны хөнгөлөлт	69,295,600.00	94,372,500.00
19	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	138,401,604.90	138,090,775.64
20	Тэтгэврийн даатгалын шимтгэл	88,924,671.00	88,319,483.09
21	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	10,146,464.00	9,993,656.30
22	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,625,407.00	12,592,106.60
23	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,855,046.00	2,399,133.30
24	Эрүүл мэндийн даатгалын хураамж	23,850,016.90	24,786,396.35
25	Бараа үйлчилгээний урсгал зардал	248,032,721.10	171,914,177.95
26	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	48,950,000.00	41,677,200.00
27	Байрны түрээс	48,950,000.00	41,677,200.00
28	Хангамж, бараа материалын зардал	2,513,900.00	2,950,900.00
29	Бичиг хэрэг	800,000.00	651,700.00
30	Тээвэр, шатахуун	1,190,400.00	1,072,700.00
31	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	367,100.00	1,100,800.00
32	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	156,400.00	125,700.00
33	Нормативт зардал	686,000.00	1,570,000.00
34	Нормын хувцас, зөөлөн эдлэл	686,000.00	1,570,000.00
35	Томилолт, зочны зардал	590,300.00	224,700.00
36	Дотоод албан томилолт	590,300.00	224,700.00
37	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	193,339,197.00	109,929,200.00
38	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчи	192,132,697.00	107,933,500.00
39	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	673,800.00	1,000,000.00
40	Даатгалын үйлчилгээ	274,000.00	274,000.00

41	Тээврийн хэрэгслийн татвар	225,700.00	225,400.00
42	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
43	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	463,300.00
44	Бараа үйлчилгээний бусад зардал	1,953,324.10	15,562,177.95
	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	10,354,292.50
45	Татан төвлөрүүлэх	1,953,324.10	5,207,885.45
46	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,445,713.79	19,527,100.00
47	Бусад урсгал шилжүүлэг	39,445,713.79	19,527,100.00
48	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэвэр	34,753,710.00	19,527,100.00
49	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	4,692,003.79	00.00
50	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	1,684,694,361.79	1,601,037,089.59
51	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
52	Хөрөнгийн орлого	00.00	00.00
53	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
54	Засгийн газрын бондын үндсэн төлбөр	00.00	00.00
55	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр	00.00	00.00
56	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
57	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
58	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

Бэлтгэсэн: Аудитор

Д.Төмөрбаатар

УЛСЫН ФИЛАРМОНИ

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

16.12.31

/төгр

№	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээ	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
1	2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	390,738,376.57	84,822,555.81	369,373,946.86	844,934,879.24
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	390,738,376.57	84,822,555.81	369,373,946.86	844,934,879.24
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	00.00	00.00	00.00	00.00
7	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-206,737,451.89	-206,737,451.89
8	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	390,738,376.57	84,822,555.81	162,967,801.97	638,528,734.35
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	390,738,376.57	84,822,555.81	162,967,801.97	638,528,734.35
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	00.00	00.00	00.00	00.00
14	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-199,187,691.74	-199,187,691.74
15	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	390,738,376.57	84,822,555.81	-36,219,889.77	439,341,042.61

Бэлтгэсэн: Аудитор

Д.Төмөрбаатар

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2.31

/л

№	Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,552,343,100.00	1,551,682,890.64	660,209.36	99.96
2	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,552,343,100.00	1,551,682,890.64	660,209.36	99.96
3	IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,552,343,100.00	1,551,682,890.64	660,209.36	99.96
4	Бараа, үйлчилгээний зардал	1,532,816,000.00	1,532,155,790.64	660,209.36	99.96
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,260,239,000.00	1,260,213,015.00	25,985.00	100.00
6	Үндсэн цалин	1,165,866,500.00	1,165,840,515.00	25,985.00	100.00
7	Нэмэгдэл цалин	00.00	00.00	00.00	00.00
8	Унаа, болон бусад нөхөн олговор	94,372,500.00	94,372,500.00	00.00	100.00
9	Үр дүнгийн урамшуулал	00.00	00.00	00.00	00.00
10	Гэрээтийн цалин	00.00	00.00	00.00	00.00
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	138,626,300.00	138,090,775.64	535,524.36	99.61
12	Тэтгэврийн даатгал	88,204,097.00	88,319,483.09	-115,386.09	100.13
13	Тэтгэмжийн даатгал	10,091,133.00	9,993,656.30	97,476.70	99.03
14	ҮОМШӨ ний даатгал	12,605,550.00	12,592,106.60	13,443.40	99.89
15	Ажилгүйдлийн даатгал	2,514,420.00	2,399,133.30	115,286.70	95.42
16	Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	25,211,100.00	24,786,396.35	424,703.65	98.32
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,677,200.00	41,677,200.00	00.00	100.00
18	Гэрэл цахилгаан	00.00	00.00	00.00	00.00
19	Түлш, халаалт	00.00	00.00	00.00	00.00
20	Цэвэр, бохир ус	00.00	00.00	00.00	00.00
21	Байрны түрээс	41,677,200.00	41,677,200.00	00.00	100.00
22	Хангамж, бараа материалын зардал	2,950,900.00	2,950,900.00	00.00	100.00
23	Бичиг хэрэг	651,700.00	651,700.00	00.00	100.00
24	Тээвэр (шатахуун)	1,072,700.00	1,072,700.00	00.00	100.00
25	Шуудан холбоо	1,100,800.00	1,100,800.00	00.00	100.00
26	Ном хэвлэл авах	00.00	00.00	00.00	00.00
27	Хог хаягдал устгах цэвэрлэх	00.00	00.00	00.00	00.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	125,700.00	125,700.00	00.00	100.00

29	Нормативт зардал	1,570,000.00	1,570,000.00	00.00	100.00
30	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	00.00	00.00	00.00	00.00
31	Хоол, хүнс	00.00	00.00	00.00	00.00
32	Нормын хувцас зөөлөн эдлэл	1,570,000.00	1,570,000.00	00.00	100.00
33	Эд хогшил худалдан авах	00.00	00.00	00.00	00.00
34	Багаж, техник, хэрэгсэл	00.00	00.00	00.00	00.00
35	Тавилга	00.00	00.00	00.00	00.00
36	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	00.00	00.00	00.00	00.00
37	Урсгал засвар	00.00	00.00	00.00	00.00
38	Томилолт, зочны зардал	305,100.00	224,700.00	80,400.00	73.65
39	Гадаад албан томилолт	00.00	00.00	00.00	00.00
40	Дотоод албан томилолт	305,100.00	224,700.00	80,400.00	73.65
41	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00	00.00	00.00
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	87,447,500.00	87,429,200.00	18,300.00	99.98
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,451,500.00	85,433,500.00	18,000.00	99.98
44	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,000,000.00	1,000,000.00	00.00	100.00
45	Даатгалын үйлчилгээ	274,000.00	274,000.00	00.00	100.00
46	Тээврийн хэрэгслийн татвар	225,700.00	225,400.00	300.00	99.87
47	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	33,000.00	00.00	100.00
48	Мэдээллийн технологийн зардал	463,300.00	463,300.00	00.00	100.00
49	Газрын төлбөр	00.00	00.00	00.00	00.00
50	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00	00.00	00.00
51	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	00.00	00.00	00.00	00.00
52	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	00.00	00.00
53	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	00.00	00.00	00.00
54	Татан төвлөрүүлэх	00.00	00.00	00.00	00.00
55	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,527,100.00	19,527,100.00	00.00	100.00
56	Засгийн газар хоорондын шилжүүлэг	00.00	00.00	00.00	00.00
57	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	00.00	00.00
58	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.00	00.00	00.00	00.00
59	Бусад урсгал шилжүүлэг	19,527,100.00	19,527,100.00	00.00	100.00
60	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	00.00	00.00	00.00
61	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	00.00	00.00	00.00
62	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	00.00	00.00	00.00	00.00

63	Төрөөс иргэдэд олгох бусад тэтгэмж, дэмжлэг	00.00	00.00	00.00	00.00
64	Ээлжийн амралтаар орон нутаг явах унааны зардал	00.00	00.00	00.00	00.00
65	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,527,100.00	19,527,100.00	00.00	100.00
66	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	00.00	00.00	00.00	00.00
67	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,552,343,100.00	1,551,682,890.64	660,209.36	99.96
68	НД-ийн сангаас санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
69	ЭМД-аас санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
70	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,500,000.00	90,047,676.09	-4,547,676.09	105.32
71	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00	00.00	00.00
72	Төсвөөс санхүүжих	1,466,843,100.00	1,461,635,214.55	5,207,885.45	99.65
73	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
74	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
75	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	00.00	00.00
76	АЖИЛЛАГСАД БҮГД	150.00	171.00	00.00	100.00
77	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.00
78	Гүйцэтгэх ажилтан	130.00	151.00	00.00	100.00
79	Үйлчлэх ажилтан	19.00	19.00	00.00	100.00

Бэлтгэсэн: Аудитор

Д.Төмөрбаатар